



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 07 болон 08 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 02-р сарын 19-нөөс 03-р сарын 04-ний байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны гурав дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- НҮБ-аас 2021 оны 3-р сарын 1-нд нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал” тайланд өсөн нэмэгдэж буй төсвийн алдагдал болон Засгийн газрын өрийн асуудлыг онцолж авч үзжээ. Өнгөрсөн онд Евро бүс, Япон, АНУ-ын Засгийн газраас гаргасан өрийн дийлэнх хувийг санхүүгийн сектор болон Төв банкууд нь худалдан авчээ. Эдгээр худалдан авалт нь санхүүгийн секторын активыг өсгөсөн бол пассив талдаа санхүүгийн бус сектор болон иргэдийн хадгаламж өссөн байна. Ийнхүү баланс дахь эх үүсвэрийн өөрчлөлт нь шинээр босгосон Засгийн газрын өрийг иргэд болон санхүүгийн бус сектор шууд бусаар санхүүжүүлсэн болохыг харуулж байна. Цар тахлын вакцинжуулалт үргэлжилж, хэрэглэгчийн итгэл сэргэн, иргэдийн хэрэглээ, хөрөнгө оруулалт нэмэгдмэгц цаашид Засгийн газрын бондын эрэлт буурч болзошгүй байна. Ийм нөхцөлд бодлого боловсруулагчид төсвийн дэмжлэгийг үргэлжлүүлэх, гадаад өрийг дахин санхүүжүүлэхэд хүү өсч болох тул сорилттой тулгарч болзошгүйг тус байгууллагаас анхаарууллаа.
- Дэлхийн томоохон гүрнүүдэд **цар тахлын үеэр иргэд 2.9 их наяд ам.долларыг хадгалсан бөгөөд энэ нь эдийн засгийн сэргэлтэд түлхэц болно** гэж Блүүмбергийн эдийн засагчид үзэж байна. Тухайлбал, АНУ, БНХАУ, Япон болон Европын томоохон орнуудын хэрэглэгчид 2020 онд хөл хорионд орж, хэрэглээгээ танахаас аргагүй нөхцөлд оржээ. Энэхүү хадгаламжийн хагас нь буюу 1.5 их наяд ам.долларыг АНУ дангаараа бүрдүүлсэн байна. Вакцинжуулалт эрчимжиж, хөл хорио тавигдмагц хэрэглэгчид ресторан, урлаг соёлын үйлчилгээгээр үйлчлүүлж, дэлгүүр хэсэн, төлөвлөсөн ч явж чадаагүй аяллуудаа хийнэ гэж өөдрөг шинжээчид таамаглаж байна. Хэрэв АНУ-ын өмнөх онд хуримтлуулсан бүх хадгаламжаа хэрэглээнд зарцуулбал АНУ-ын эдийн засаг 2021 онд суурь төсөөлөл 4.6 хувиас нэмэгдэж 9 хувьд хүрч өсөх, хуримтлалаа огт зарцуулахгүй бол 2.2 хувиар өсөх боломжтой гэж Блүүмбергийн эдийн засагчид тооцоолжээ.



- Шилжилт хөдөлгөөн, эрчим хүчний хэрэглээ, олон нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг өндөр давтамжтай индикаторуудыг харахад **2021 оны 2-р сард бүх томоохон эдийн засгуудын үйл ажиллагаа сэргэсэн** гэж Блүүмбергээс мэдээллээ. Эдийн засгийн үйл ажиллагаа АНУ, Испанид хүчтэй сэргэсэн бол Канад, Их Британид алгуур сэргэж байна.
- **The Conference Board** байгууллагын 2021 оны 2-р сарын “Дэлхийн эдийн засгийн төлөв байдал” тайланд **дэлхийн эдийн засаг 2021 онд 4.4 хувиар өсөх** төсөөллийг нийтэллээ. 2008-09 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үед дэлхийн гадаад худалдаа хямралын өмнөх түвшинд хүрэхэд 30 сар зарцуулсан бол цар тахлын хямралын үед 7 сарын хугацаанд (2020 оны 11-р сард) цар тахлын өмнөх түвшинд эргэж хүрсэн буюу барааны хэрэглээ хурдтай сэргэж байна. Вакцинжуулалт үргэлжилж,

2021 оны 2, 3-р улиралд эдийн засгийн сэргэлтийг хурдасгах нөлөөтэй байх боловч цар тахлын хямралд хүчтэй өртсөн секторууд 2022 оны дунд үе хүртэл хямралын өмнөх түвшинд хүрэхээргүй байна. Дэлхийн эдийн засаг 2020-2023 онд дунджаар 1.7 хувийн өсөлттэй байхаар төсөөлсөн нь өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар сайжирсан дүн юм. Үүнд хөгжингүй орнуудад цар тахал хяналтанд орж, дотоод эрэлт сэргэх, технологи, эрүүл мэндийн бүтээгдэхүүний гадаад эрэлт өсөх болон АНУ, Японы төсвийн дэмжлэг нэмэгдэж, эдийн засгийн өсөлт хурдсах төлөвтэй байгаа нь голлон нөлөөлөх юм.

Эх сурвалж:

1. Bloomberg, [Consumers Saved \\$2.9 Trillion During the Pandemic. Their Money Will Drive the Global Recovery](#)
2. United Nations, [World Economic Situation And Prospects: March 2021 Briefing, No 147](#)
3. The Conference Board, [Global Economic Outlook March 2021](#)

2

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын Caixin боловсруулах үйлдвэрлэлийн PMI индекс¹** 2021 оны 1-р сард 51.5 байсан бол 2-р сард хүлээлтээс багаар өсч 50.9-д буюу 2020 оны 6-р сараас бага түвшинд хүрэв. Тус индекс нь улирлын зохицуулалттай индекс тул Цагаан сартай холбоотой эдийн засгийн идэвхжил буурах нөлөөг засварласан бөгөөд улс орнуудад өрнөсөн цар тахлын өвлийн хоёр дахь давалгаа хэрэглээ болон бизнесийн үйл ажиллагаанд хүлээлтээс давж сэргөөр нөлөөлсөн байж болзошгүйг Блүүмбергийн шинжээчид онцолж байна. Гэсэн хэдий ч өндөр давтамжтай тоон мэдээллээр бизнес

эрхлэгчдийн сентимент өөдрөг чиглэлд хэвээр, тус индексийн өсөлтөд Цагаан сарын дараах эдийн засгийн идэвхжил бүрэн тусаагүй байж болох талтай. БНХАУ-ын үйлдвэрлэлийн салбарын цар тахлын хөл хорионы дараах өндөр идэвхжил үргэлжилж буй нөлөөгөөр богино хугацаанд экспортын өсөлт хадгалагдах төлөвтэй бол оны эцэст улс орнуудын үйлдвэрлэл өсөх нөлөөгөөр БНХАУ-ын үйлдвэрлэл эргээд буурч болзошгүй байна.

- **БНХАУ-ын Засгийн газраас орон сууцны үнийн халалтыг тогтворжуулах** хүрээнд бодлогын

¹ Caixin PMI индекс нь албан ёсны PMI индекстэй харьцуулахад илүү экспортод

суурилсан бөгөөд улирлын зохицуулалт сайтай байдаг.

төлөвийг алгуур чангаруулах төлөвтэй байгаа.

- БНХАУ-ын 70 том хотын орон сууцны үнийн индекс 2015 оны 5-р сараас хойш сар бүр өсөлттэй байгаа бол 1-р зэрэглэлийн хотууд дахь орон сууцны үнэ 2020 оны 2-р улирлаас хойш нэмэгдсээр байна. Нийт олгосон зээл 2011 оноос 2020 оны хооронд 2.2 дахин нэмэгдсэн бол үл хөдлөх салбарт олгосон зээл 3.6 дахин нэмэгдэв. Иймд ХАБ болон БНХАУ-ын Банк, Даатгалын зохицуулах хорооноос арилжааны банкуудыг энэ оноос хэрэгжиж буй “3 улаан шугам”-ын зарчмыг баримталж үл хөдлөх хөрөнгийн салбар дахь зээлийн төвлөрлийг бууруулах, журамд заасны дагуу орон сууцны зээл нь үл хөдлөх хөрөнгийн салбарын санхүүжилтийн тодорхой хувиас хэтрэхгүй байхыг шаардаж байна. Түүнчлэн, 1-р зэрэглэлийн хот болох Шенжен, 2-р зэрэглэлийн хот болох Хангжоу зэрэг хотуудад орон сууцны үнийн хэт халалтыг бууруулах зорилгоор орон нутгийн удирдлагаас орон сууц худалдан авах журмыг чангаруулжээ.
- Тус арга хэмжээний нөлөөгөөр орон нутгийн удирдлагын төсөв бүрдүүлэлт буурахаар байгаа тул одоогийн байдлаар эрх баригчид ажиглах бодлого баримтлахаар байна. Орон сууцны салбар дахь хөрөнгө оруулалт 2020 онд БНХАУ-ын нийт үл хөдлөх салбар дахь хөрөнгө оруулалтын 20 хувь, ДНБ-ий 10.3 хувийг бүрдүүлжээ. Орон нутгийн захиргааны төсөв бүрдүүлэлтэд газрын худалдаа 2020 онд 8.4 их наяд юань хүрч улсын нэгдсэн төсөвт хуримтлуулах дүн болон орон нутгийн нийт төсвийн орлогын 44 хувьтай тэнцэв.
- 2021 оны 3-р сарын эхний долоо хоногт болох **БНХАУ-ын Ардын Их**

ээлжит хурлаар **2021 онд Блүүмберг байгууллагын тооцооллоор дараах бодлогын чиглэл баримтлах төлөвтэй** гэдгийг онцолж байв. Үүнд: 2021 онд ДНБ-ий өсөлтийн зорилт тавихгүй бөгөөд цаашид ч тоон хувиар илэрхийлэгдэх зорилт тавихгүй байх шийдвэрт хүрч болзошгүй.

- 2021 онд ДНБ-ий өсөлтийн зорилт тавихгүй бөгөөд цаашид ч тоон хувиар илэрхийлэгдэх зорилт тавихгүй байх шийдвэрт хүрч болзошгүй.
- Эдийн засгийн бодлого илүү алгуур нормальчлах чиглэлд хэрэгжих төлөвтэй. Хэт зөөлөн төсөв, мөнгөний бодлогын нөлөө огцом арилахгүй, алгуур үргэлжлэхээр байна.
- Блүүмберг байгууллагын тооцооллоор төсвийн алдагдал (нэгдсэн төсвийн алдагдал+тусгай зориулалттай бонд+орон нутгийн захиргаанаас гаргасан бонд) 2020 онд ДНБ-ий 8.3 хувьтай тэнцэх төлөвтэй бол 2021 онд ДНБ-ий 5.9-6.1 хувьд хүрч буурах хүлээлттэй.
- Нэгдсэн төсвийн алдагдлын зорилтыг 2020 онд ДНБ-ий 3.6 хувьтай тэнцэж байсан бол энэ онд ДНБ-ий 3 хувьд, тусгай зориулалттай Засгийн газрын бондын хэмжээ өмнөх оны 3.75 их наяд юаниас 2021 онд 3.25-3.5 их наяд юаньд хүрч тус тус бууруулахаар байна.
- ХАБ нэг жилийн хугацаатай зээлийн хүүгээ (1 year Loan Prime Rate) тогтвортой хадгалахаар байгаа ч оны сүүл рүү 0.1 нэгж хувиар бууруулах хүлээлттэй.
- Энэ жил “14 дахь 5 жилийн төлөвлөгөө” болон “2035 оны алсын хараа” төлөвлөгөөний эхний жил бөгөөд 2021 онд хэрэгжүүлэх бодлогын чиглэл ирэх жилүүдэд хадгалагдах магадлалтай. 2020 оны 11-р сард БНХАУ 2035 он гэхэд “дундаж



хөгжсөн улс” болохоо зарласан бөгөөд тус зорилгод хүрэхийн тулд жилд дунджаар ДНБ 4.7-5 хувиар өсөх шаардлагатайг Блүүмбергийн шинжээчид онцлов.

- Хүлэмжийн хийг бууруулах хүрээнд төвийг сахих төлөв, дотоодын хэрэглээ, технологийн хөгжлийг тус тус дэмжих, илүү дотоод эрэлтэд суурилсан өсөлт болон зах зээлээ илүү тэлэх (санхүүгийн салбартаа түлхүү), гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй байдлыг нэмэгдүүлэх зэрэг бодлого баримтлах төлөвтэй.
- БНХАУ 2030 он гэхэд шинээр үүсэх хүлэмжийн хийн хэмжээг түүхэн доод түвшинд хүргэж бууруулах, 2060 он гэхэд (carbon neutrality) хүлэмжийн хийгээ бүрэн хязгаарлах амлалт өгөв. Энэ удаагийн Ардын Их Хурлаар дараах зорилтот хэрхэн хүрэх талаар илүү дэлгэрэнгүй чиглэл гарахаар байна.

- Энэ оны 3-р сард болох Ардын Их Хурлын төлөв, Цагаан сарын дараа нүүрсний эрэлт бага зэрэг нэмэгдсэн ч нөөц, үйлдвэрлэл нэмэгдэхээр байгаа тул нүүрсний үнэ төдийлөн нэмэгдэхээргүй байна. Австралийн нүүрсийг БНХАУ-ын боомтууд дээр буулгах зөвшөөрөл олгосон ч гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй хэвээр байгаа бол Ганцмод боомтоор Монголын нүүрсний автомашинуудын нэвтрэх тоо өмнөх долоо хоногоос 142 машинаар нэмэгдэж, нүүрсний үнэ тонн тутамд 50 юаниар буурчээ.

Эх сурвалж:


1. *China React: Exporters Hit Lull-Caixin PMI, It won't last, Bloomberg*
2. *China Preview: No sharp turn at NPC – Taper, Set Long-Run Course, Bloomberg*
3. *China Insight: 'Bubble' warning signals more housing tightening, Bloomberg*

3

МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (-1 day) 2021/03/01	Өөрчлөлт					Товч тайлбар
		daily	weekly	monthly	year to date	YoY	
Зэс	9220.3	0.0%	-0.1%	18.4%	19.0%	63.3%	Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсээр байгаа хэдий ч улс орнуудад вакцинжуулалт эхэлсэн нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ хадгалагдахад нөлөөлж байна.
Төмрийн хүдэр	165	0.0%	1.0%	6.9%	8.1%	98.2%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлттэй тул төмрийн хүдрийн эрэлт сайн байх төлөв, өвлийн саруудад идэвхжил нэмэгдсэнтэй холбоотойгоор үнэ нэмэгдэв.
Алт	1725	0.8%	-3.7%	-5.4%	-8.4%	5.9%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал бүрэн буураагүй, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна. Гэсэн хэдий ч улс орнуудад вакцинжуулалт эхэлсэн гэсэн мэдээ зах зээл дэх тодорхой бус байдлыг бууруулж алтны үнэ буурахад нөлөөлөв.
Газрын тос (Брент)	62.6	0.1%	-6.5%	7.3%	22.7%	20.9%	ОПЕК+-ийн нэгдэл энэ сард болох ээлжит хэлэлцээрээрээ нийлүүлэлтийг бага зэрэг нэмэгдүүлж болзошгүй, АНУ-ын нөөц өмнөх долоо хоногоос 21 сая баррелиар нэмэгдсэн зэрэг нь үнийг бууруулах чиглэлд нөлөөлж байна. Олон улсын эрчим хүчний байгууллагын тооцооллоор дэлхийн газрын тосны эрэлт 2021 оны дунд хүртэл төдийлөн нэмэгдэхээргүй байна.

Зураг 1. Дэлхийн зах зээл дээрх алт, төмрийн хүдрийн спот үнэ



Зураг 2. Дэлхийн зах зээл дээрх зэс, газрын тосны үнэ

